



I-IX/2021

Тархаасан: 2021 оны 10 дугаар сарын 8



ХҮН АМ

Улсын хэмжээнд 2021 оны эхний 9 сарын байдлаар 54 515 эх амаржиж, 54 896 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 2 541 (4.5%)-ээр, төрсөн хүүхэд 2 594 (4.5%)-өөр тус тус буурчээ.

ЗУРАГ 1. ТӨРӨЛТ, жил бүрийн эхний 9 сарын байдлаар



1000 хүнд ногдох төрөлт өмнөх оны мөн үеэс 1.0 нэгжээр буурсан байна.

1000 хүнд ногдох төрөлт Улаанбаатар хот болон Баян-Өлгий, Говьсүмбэр, Орхон, Өмнөговь, Ховд, Говь-Алтай, Увс, Сүхбаатар аймагт улсын дунджаас 0.3-3.6 нэгжээр дээгүүр, бусад аймагт 0.1-6.9 нэгжээр доогуур байна.

ЗУРАГ 2. НАС БАРАЛТ, жил бүрийн эхний 9 сарын байдлаар



Нас баралт 13 894 болж, өмнөх оны мөн үеэс 1 896 (15.8%)-аар өсжээ. 1000 хүнд ногдох төрөлт 16.2, нас баралт 4.1, ердийн цэвэр өсөлт 12.1 байна.

1000 хүнд ногдох нас баралт өмнөх оны мөн үеэс 0.5 нэгжээр өсжээ.

1000 хүнд ногдох нас баралт Улаанбаатар хот болон Завхан, Дорнод, Сүхбаатар аймагт улсын дунджаас 0.1-0.3 нэгжээр дээгүүр, Баянхонгор, Хөвсгөл аймагт ижил түвшинд, харин бусад аймагт 0.1-1.0 нэгжээр доогуур байна.

1000 хүнд ногдох ердийн цэвэр өсөлт Улаанбаатар хот болон Баян-Өлгий, Говьсүмбэр, Өмнөговь, Орхон, Ховд, Говь-Алтай, Увс, Дархан-Уул, Сүхбаатар аймагт улсын дунджаас 0.2-4.6 нэгжээр дээгүүр, харин бусад аймагт 0.1-6.7 нэгжээр доогуур байна.

ХҮСНЭГТ 1. 1000 ХҮНД НОГДОХ ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, ЕРДИЙН ЦЭВЭР ӨСӨЛТ, бүс, аймаг, нийслэлээр, 2021 оны эхний 9 сарын байдлаар

| Аймаг, нийслэл | Төрөлт | Нас баралт | Ердийн цэвэр өсөлт |
|----------------|-------------|------------|--------------------|
| Дүн | 16.2 | 4.1 | 12.1 |
| Баруун бүс | 17.2 | 3.7 | 13.5 |
| Баян-Өлгий | 19.8 | 3.1 | 16.7 |
| Говь-Алтай | 16.8 | 4.0 | 12.8 |
| Завхан | 14.6 | 4.2 | 10.4 |
| Увс | 16.6 | 3.9 | 12.7 |
| Ховд | 16.9 | 3.4 | 13.5 |
| Хангайн бүс | 14.8 | 4.0 | 10.8 |
| Архангай | 13.6 | 4.0 | 9.6 |
| Баянхонгор | 16.1 | 4.1 | 12.0 |
| Булган | 11.2 | 3.8 | 7.4 |
| Орхон | 17.7 | 4.0 | 13.7 |
| Өвөрхангай | 14.2 | 3.9 | 10.3 |
| Хөвсгөл | 14.7 | 4.1 | 10.6 |
| Төвийн бүс | 13.8 | 3.6 | 10.2 |
| Говьсүмбэр | 19.4 | 3.5 | 15.9 |
| Дархан-Уул | 15.6 | 3.2 | 12.4 |
| Дорноговь | 15.3 | 3.4 | 11.9 |
| Дундговь | 14.0 | 4.0 | 10.0 |
| Өмнөговь | 17.3 | 3.2 | 14.1 |
| Сэлэнгэ | 11.4 | 3.7 | 7.7 |
| Төв | 9.3 | 3.9 | 5.4 |
| Зүүн бүс | 15.8 | 3.9 | 11.9 |
| Дорнод | 16.1 | 4.2 | 11.9 |
| Сүхбаатар | 16.5 | 4.2 | 12.3 |
| Хэнтий | 14.8 | 3.5 | 11.3 |
| Улаанбаатар | 17.2 | 4.4 | 12.8 |

Тайлбар: Эрүүл мэндийн яамны төрөлт, нас баралтын мэдээнд үндэслэн тооцов.

Ойлголт, тодорхойлолт

Хүн амын ердийн цэвэр өсөлтийг төрөлт, нас баралтын зөрүүгээр тодорхойлно.



Эх үүсвэр:

Эрүүл мэндийн яам

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ гаргаах хуваарь: 2022 оны 1 дүгээр сарын 14

Тооллого, өгөгдлийн шинжилгээний
газрын дарга Ш.Ариунболд
Утас : (976-51)-261523

Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын
статистикч Т.Ариунсайхан
Утас : (976-51)-267547

